ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2022.02.21 № 98

танай 2022.01.17 -ны № 12 -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЦЭЦЭГСҮРЭН ТАНАА

Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийж тайлан, гэрчилгээг хүргүүлэв.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР

009030196

D:\Бичиг хэрэг\alban bishig A5 - 2022.docx

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: ДАА-2022/09/НА-СА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр**
Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**
Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn



Дархан-Уул аймаг

2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....2
3. Аудитын тайлан ....11
3.1 Ерөнхий зүйл ....11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....12
3.4 Материаллаг байдал....13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....15
3.8 Аудитын гол асуудал....15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16
4. Аудитын илрүүлэлт....16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....17

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НҮТББ | Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2021.02.21 № 98

танай ____________-ны № ____________-т

ТӨВ НОМЫН САНГИЙН ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЦЭЦЭГСҮРЭН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

01 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР

0090?0080

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,624,932.00** | **6,450,082.00** |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 6,624,932.00 | 6,450,082.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 6,624,932.00 | 6,450,082.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,322,380.00 | 1,296,030.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,189,052.00 | 4,174,052.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 133,500.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 980,000.00 | 980,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **357,755,839.80** | **379,446,976.93** |
| 37 | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | | |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 357,755,839.80 | 379,446,976.93 |
| 391 | Газар | | |
| 392 | **Биет хөрөнгө** | 308,045,259.72 | 329,961,256.81 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 110,688,504.00 | 110,688,504.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (4,969,085.76) | (7,453,628.64) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 21,400,000.00 | 21,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (21,400,000.00) | (21,400,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 48,909,582.80 | 56,628,418.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (43,771,007.08) | (36,403,480.51) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 31,399,856.70 | 29,800,537.04 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (19,212,523.73) | (17,002,852.03) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,289,000.00 | 5,289,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (602,138.76) | (767,255.40) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | |
| 39217 | Ном | 180,313,071.55 | 189,182,013.55 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 49,710,580.08 | 49,485,720.12 |
| 39301 | Програм хангамж | 4,772,325.00 | 3,580,325.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (4,097,744.92) | (3,130,604.88) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 49,036,000.00 | 49,036,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **364,380,771.80** | **385,897,058.93** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **364,380,771.80** | **385,897,058.93** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 364,380,771.80 | 385,897,058.93 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 262,683,838.46 | 262,683,838.46 |
| 51101 | Өмч: - төрийн | 262,683,838.46 | 262,683,838.46 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 65,212,762.11 | 86,729,049.24 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 67,953,815.42 | 65,212,762.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (2,741,053.31) | 21,516,287.13 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 513 | **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | 36,484,171.23 | 36,484,171.23 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **364,380,771.80** | **385,897,058.93** |

01 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар*

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **371,211,080.00** | **269,431,060.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,297,780.00** | **17,938,460.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,297,780.00** | **17,938,460.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 360,000.00 | 1,200,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 360,000.00 | 1,200,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 2,937,780.00 | 16,738,460.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **367,913,300.00** | **251,492,600.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,265,000.00** | **2,923,500.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,265,000.00 | 1,673,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,250,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **366,648,300.00** | **248,569,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 366,648,300.00 | 248,569,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **373,952,133.31** | **240,927,554.87** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **373,952,133.31** | **240,927,554.87** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **240,404,237.68** | **237,948,280.42** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 190,822,280.71 | 183,476,303.05 |
| 210101 | Үндсэн цалин | 143,692,235.71 | 127,782,112.39 |
| 210102 | Нэмэгдэл | 38,195,453.00 | 35,774,749.16 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,525,900.00 | 6,273,643.00 |
| 210104 | Урамшуулал | 5,408,692.00 | 13,645,798.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,853,000.00 | 24,793,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,220,100.00 | 17,062,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,908,200.00 | 1,932,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,526,600.00 | 1,546,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 381,600.00 | 386,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,816,500.00 | 3,865,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,814,404.50 | 4,235,792.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 500,000.00 | 1,625,894.59 |
| 210302 | Түлш, халаалт | 2,997,805.72 | 2,559,280.66 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 316,598.78 | 50,617.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,878,629.48 | 7,149,858.25 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,205,850.00 | 1,904,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 430,000.00 | 331,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,592,227.16 | 3,292,658.25 |
| 210404 | Ном, хэвлэл | 392,000.00 | 16,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000.00 | 208,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,103,552.32 | 1,396,550.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 95,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 138,700.00 | 767,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 138,700.00 | 767,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 607,760.00 | 7,097,550.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 40,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 567,760.00 | 7,097,550.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 100,700.00 | 128,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 100,700.00 | 128,000.00 |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,012,912.00 | 2,874,972.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,062,000.00 | 2,044,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 65,340.00 | 95,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 64,500.00 | 64,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 98,072.00 | 98,072.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 150,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,175,850.99 | 7,425,204.87 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 6,175,850.99 | 7,425,204.87 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 133,547,895.63 | 2,979,274.45 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 129,022,572.83 | 2,646,700.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 128,102,572.83 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 920,000.00 | 2,646,700.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,525,322.80 | 332,574.45 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,525,322.80 | 332,574.45 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(2,741,053.31)** | **28,503,505.13** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **6,987,218.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө акталсны гарз | | 6,987,218.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | **(6,987,218.00)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(2,741,053.31)** | **21,516,287.13** |

*Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар*

ХТ05430 ⊕ 9022899

01 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл** | **262,683,838.46** | **36,484,171.23** | **67,953,815.42** | **367,121,825.11** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **262,683,838.46** | **36,484,171.23** | **67,953,815.42** | **367,121,825.11** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (2,741,053.31) | (2,741,053.31) |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **262,683,838.46** | **36,484,171.23** | **65,212,762.11** | **364,380,771.80** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл** | **262,683,838.46** | **36,484,171.23** | **65,212,762.11** | **364,380,771.80** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **262,683,838.46** | **36,484,171.23** | **65,212,762.11** | **364,380,771.80** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 21,516,287.13 | 21,516,287.13 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **262,683,838.46** | **36,484,171.23** | **86,729,049.24** | **385,897,058.93** |

*Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар*

ХТО5430 ® 9022899

01 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **368,273,300.00** | **252,692,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **360,000.00** | **1,200,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **360,000.00** | **1,200,000.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 360,000.00 | 1,200,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 360,000.00 | 1,200,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **367,913,300.00** | **251,492,600.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,265,000.00 | 2,923,500.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,265,000.00 | 1,673,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,250,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **366,648,300.00** | **248,569,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 366,648,300.00 | 248,569,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **366,347,100.00** | **233,327,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **366,347,100.00** | **233,327,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **232,572,484.37** | **230,348,225.55** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 190,822,280.71 | 183,476,303.05 |
| 210101 | Үндсэн цалин | 143,692,235.71 | 127,782,112.39 |
| 210102 | Нэмэгдэл | 38,195,453.00 | 35,774,749.16 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,525,900.00 | 6,273,643.00 |
| 210104 | Урамшуулал | 5,408,692.00 | 13,645,798.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,853,000.00 | 24,793,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,220,100.00 | 17,062,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,908,200.00 | 1,932,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,526,600.00 | 1,546,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 381,600.00 | 386,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,816,500.00 | 3,865,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,814,404.50 | 4,235,792.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 500,000.00 | 1,625,894.59 |
| 210302 | Түлш, халаалт | 2,997,805.72 | 2,559,280.66 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 316,598.78 | 50,617.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,035,977.16 | 6,681,758.25 |
| 210401 | Бичиг хэрэг | 893,400.00 | 1,016,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 198,500.00 | 198,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,592,227.16 | 3,292,658.25 |
| 210404 | Ном, хэвлэл | 350,000.00 | 448,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000.00 | 197,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 941,850.00 | 1,528,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 193,000.00 | 763,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 193,000.00 | 763,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 424,310.00 | 6,940,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | - |
| 210604 | Урсгал засвар | 424,310.00 | 6,940,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 100,700.00 | 128,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 100,700.00 | 128,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,328,812.00 | 3,329,972.00 |

01 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,062,000.00 | 2,499,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 65,340.00 | 95,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 64,500.00 | 64,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 98,072.00 | 98,072.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 465,900.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **133,774,615.63** | **2,979,274.45** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 129,249,292.83 | 2,646,700.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 128,102,572.83 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,146,720.00 | 2,646,700.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,525,322.80 | 332,574.45 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,525,322.80 | 332,574.45 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,926,200.00** | **19,365,100.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 4 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | | |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,926,200.00** | **19,365,100.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,926,200.00** | **19,365,100.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,926,200.00 | 19,365,100.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 844,800.00 | 5,947,900.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 1,081,400.00 | 13,417,200.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,926,200.00)** | **(19,365,100.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

*Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар*

ХТО5430 9022599

01
ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **249,769,100.00** | **249,436,525.55** | **(332,574.45)** | 99.9 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 249,769,100.00 | 249,436,525.55 | (332,574.45) | 99.9 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 248,272,400.00 | 247,939,825.55 | (332,574.45) | 99.9 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 183,484,500.00 | 183,476,303.05 | (8,196.95) | 100.0 |
| Үндсэн цалин | 122,296,300.00 | 127,782,112.39 | 5,485,812.39 | 104.5 |
| Нэмэгдэл | 39,158,000.00 | 35,774,749.16 | (3,383,250.84) | 91.4 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 5,324,000.00 | 6,273,643.00 | 949,643.00 | 117.8 |
| Урамшуулал | 16,706,200.00 | 13,645,798.50 | (3,060,401.50) | 81.7 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 24,793,400.00 | 24,793,400.00 | - | 100.0 |
| Тэтгэврийн даатгал | 17,062,000.00 | 17,062,000.00 | - | 100.0 |
| Тэтгэмжийн даатгал | 1,932,800.00 | 1,932,800.00 | - | 100.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,546,300.00 | 1,546,300.00 | - | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 386,600.00 | 386,600.00 | - | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 3,865,700.00 | 3,865,700.00 | - | 100.0 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,382,900.00 | 4,235,792.25 | (147,107.75) | 96.6 |
| Гэрэл, цахилгаан | 1,546,500.00 | 1,625,894.59 | 79,394.59 | 105.1 |
| Түлш, халаалт | 2,416,400.00 | 2,559,280.66 | 142,880.66 | 105.9 |
| Цэвэр, бохир ус | 420,000.00 | 50,617.00 | (369,383.00) | 12.1 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 19,731,500.00 | 19,575,458.25 | (156,041.75) | 99.2 |
| Бичиг хэрэг | 893,400.00 | 941,800.00 | 48,400.00 | 105.4 |
| Тээвэр, шатахуун | 198,500.00 | 198,000.00 | (500.00) | 99.7 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,448,000.00 | 3,292,658.25 | (155,341.75) | 95.5 |
| Ном, хэвлэл | 13,417,200.00 | 13,417,200.00 | - | 100.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 197,600.00 | 197,400.00 | (200.00) | 99.9 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,576,800.00 | 1,528,400.00 | (48,400.00) | 96.9 |
| **Нормативт зардал** | 763,000.00 | 763,000.00 | - | 100.0 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 763,000.00 | 763,000.00 | - | 100.0 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,637,900.00 | 11,637,900.00 | - | 100.0 |
| Багаж, техник, хэрэгсэл | 4,697,900.00 | 4,697,900.00 | - | 100.0 |
| Урсгал засвар | 6,940,000.00 | 6,940,000.00 | - | 100.0 |
| **Томилолт, зочны зардал** | 129,800.00 | 128,000.00 | (1,800.00) | 98.6 |
| Дотоод албан томилолт | 129,800.00 | 128,000.00 | (1,800.00) | 98.6 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,349,400.00 | 3,329,972.00 | (19,428.00) | 99.4 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,499,000.00 | 2,499,000.00 | - | 100.0 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 | - | 100.0 |
| Даатгалын үйлчилгээ | 112,200.00 | 95,400.00 | (16,800.00) | 85.0 |

01
ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тээврийн хэрэгслийн татвар | 66,200.00 | 64,500.00 | (1,700.00) | 97.4 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | 33,000.00 | - | 100.0 |
| Газрын төлбөр | 99,000.00 | 98,072.00 | (928.00) | 99.1 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,496,700.00 | 1,496,700.00 | - | 100.0 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 1,496,700.00 | 1,496,700.00 | - | 100.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,496,700.00 | 1,496,700.00 | - | 100.0 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **249,769,100.00** | **249,436,525.55** | **(332,574.45)** | **99.9** |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 248,569,100.00 | 248,236,525.55 | (332,574.45) | 99.9 |
| Орон нутгийн төсвөөс | 248,569,100.00 | 248,236,525.55 | (332,574.45) | 99.9 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | 100.0 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | 100.0 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - | - | 0.0 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | - | - | 0.0 |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | - | 0.0 |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 15.00 | 15.00 | - | 100.0 |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 2.00 | 2.00 | - | 100.0 |
| Гэрээт ажилтан | | | - | |

*Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар*

ХТ05430 ⊕ 9022899

01
ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,923,500.00 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,673,500.00 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 523,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 523,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 75,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 448,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,150,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,150,000.00 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 1,250,000.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,250,000.00 |
| 225106 | Тоног төхөөрөмж | 1,250,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,923,500.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,923,500.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,673,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,250,000.00 |
| 4 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - |

*Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар*

01 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад цалингийн зардалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр хэрэгжүүлсэн.

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дархан-Уул аймгийн Төв номын сан нь номын сангийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага бөгөөд 2021 онд "Соёлын үйлчилгээ - хөгжлийн баталгаа" гэсэн зорилтыг дэвшүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай",
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай",
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар",
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС шинэчлэгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 249,769.1 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 4,995.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,996.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,516.3 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 6,624.9 | 6,450.1 | (174.8) |
| Үндсэн хөрөнгө | 357,755.8 | 379,447.0 | 21,691.2 |
| **Нийт хөрөнгө** | **364,380.8** | **385,897.1** | **21,516.3** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо | 364,380.8 | 385,897.1 | 21,516.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **364,380.8** | **385,897.1** | **21,516.3** |

Бараа материал дансны үлдэгдэл 174.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 9,223.6 мянган төгрөгийн материал худалдан авч, 9,398.4 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хувьд 13,417.2 мянган төгрөгийн 601 боть ном, 5,947.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг төсвөөс худалдан авч, Б.Жавхлан гишүүний ажлын албанаас 6,999.6 мянган төгрөгийн 2 ширхэг компьютер, Говийн тайга НҮТББ-аас 5,169.9 мянган төгрөгийн ном, сэтгүүл ариутгах төхөөрөмж, агаар цэвэршүүлэгч, цахим ном уншигч, 55 инчийн лед дэлгэц зэрэг тоног төхөөрөмж, 2,130.0 мянган төгрөгийн тавилга, иргэдээс 2,439.0 мянган төгрөгийн 195 боть номыг хандивласнаар үндсэн хөрөнгө өсөж, аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/398 тоот захирамжаар цаашид ашиглах боломжгүй болсон 6,987.2 мянган төгрөгийн хөрөнгө акталж, тайлант онд 7,425.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар оны эцэст 379,447.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 385,897.1 мянган төгрөг болж 21,516.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2.* Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 360.0 | 1,200.0 | 840.0 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,937.8 | 16,738.5 | 13,800.7 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,265.0 | 2,923.5 | 1,658.5 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 366,648.3 | 248,569.1 | (118,079.2) |
| **Үйл ажиллагааны орлогын дүн** | **371,211.1** | **269,431.1** | **(101,780.0)** |
| Урсгал зардал | 373,952.1 | 240,927.6 | (133,024.5) |
| Хөрөнгийн зардал | - | - | - |
| **Үйл ажиллагааны зардлын дүн** | **373,952.1** | **240,927.6** | **(133,024.5)** |

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого, зардлын 118,079.2-133,024.5 мянган төгрөгийн бууралтад өмнөх онд 4 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарч, 128,102.6 мянган төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж авсан нь голлон нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 364,683.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 126,114.1 мянган төгрөгөөр бууруулж, 238,569.1 мянган төгрөгөөр анх батлсныг 2021 оны 9 дүгээр сард 11,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 249,769.1 мянган төгрөгөөр тодотгожээ. Тодотголоор хэмнэгдэж буй цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн 11,100.0 мянга, тогтмол зардлын 900.0 мянган төгрөгийг хасаж, үндсэн үйл ажиллагааны орлогыг 1,200.0 мянга, ном худалдан авах зардлыг /сүүлийн 5 жилд шинэчлэл хийгээгүй номын фондыг нэмэгдүүлэхээр/ 10,000.0 мянга, урсгал засварыг 6,940.0 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 5,180.0 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 1,080.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 249,769.1 мянган төгрөгийн төсөв батлсны 248,569.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,200.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 248,569.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 1,200.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 249,436.5 мянган төгрөгийг зарцуулж, 332.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 249,436.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. Тодотгосон төсвөөс байр ашиглалттай холбоотой зардлыг 147.1 мянга, хангамж, бараа материалын зардал 156.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Оюунлаг Дарханчууд аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд Дархан хотын өдрийг угтан зохион байгуулсан “Миний хотын соёл” уралдааны зардалд аймгийн ЗДТГ-аас 1,673.5 мянга, үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн лавлагааг бий болгох зорилгоор Соёлын яамнаас 1,250.0 мянга, нийт 2,923.5 мянган төгрөгийн санхүүжилт орж ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## 3.8 Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансанд худалдан авалтын 6,000.2 мянган төгрөгийн 1 мэдээллийн зарцуулалтын шийдвэрийг оруулсан ч гүйлгээг мэдээлээгүй байсныг аудитын явцад нөхөн оруулж, залруулլаа.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 221.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад бүрэн барагдуулж, зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 63 тоот албан бичгээр ирүүлснийг тайлагналын дараах үе шатанд дахин хянаж, хэрэгжилтийг 100 хувиар үнэлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,947.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 6,000.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 947.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Шилэн дансны цахим системд худалдан авалтын 6,000.2 мянган төгрөгийн 1 мэдээллийн зарцуулалтын шийдвэрийг оруулсан ч гүйлгээг мэдээлээгүй байсныг аудитын явцад нөхөн оруулж, залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тус байгууллагын архив-бичиг хэргийн ажилтан, нярвын ажил үүргийг хавсран гүйцэтгэж байгаа 2 ажилтанд үндсэн ажлын албан тушаалын цалингаас хавсран ажилласны нэмэгдлийг тооцон олгосон. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д "*Ажилтны цалин хөлсийг хийснээр, ... хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно*" гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>:*

Архив-бичиг хэргийн ажилтан, нярвын ажил үүргийг хавсран гүйцэтгэж буй 2 ажилтанд дээрх албан тушаалын цалингийн сүлжээнээс хавсран ажилласны нэмэгдлийг тооцон олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Төв номын сан | 2 | 6,947.2 | 1 | 6,000.2 | - | - | - | - | 1 | 947.0 |
| Дүн | | 2 | 6,947.2 | 1 | 6,000.2 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 947.0 |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2022.02.21.